



I-X/2021

Тархаасан: 2021 оны 12 дугаар сарын 13



Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас 3.4 хувиар өслөө

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны эхний 10 сард 21.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.9 (22.0%) их наяд төгрөгөөр өслөө.

Үүнд шатахуун, хүнсний бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 10 дугаар сард 2.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 80.7 (3.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО¹, жил бүрийн эхний 10 сард


	2019*		2020*		2021*		<u>2021* I-X</u> <u>2020* I-X</u>
	Х	I-X	Х	I-X	Х	I-X	
	тэрбум төгрөг						
Нийт	1 988.1	18 889.6	2 043.6	17 599.0	2 459.7	21 464.2	122.0
Бөөний худалдаа	723.2	6 855.5	741.6	6 501.0	936.0	8 177.5	125.8
Жижиглэн худалдаа	1 264.8	12 034.1	1 302.0	11 098.0	1 523.7	13 286.7	119.7

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

2021 оны эхний 10 сард худалдааны салбарын борлуулалтын орлогын 38.1 хувь нь бөөний худалдаа, 61.9 хувь жижиглэн жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны 2021 оны эхний 10 сарын борлуулалтын орлого 13.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (19.7%) их наяд төгрөг, бөөний худалдааны 2021 оны эхний 10 сарын борлуулалтын орлого 8.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (25.8%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.


ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО,
сараар, тэрбум төгрөг



Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас 80.7 тэрбум төгрөгөөр өсөхөд шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, хүнсний барааны жижиглэн худалдаа өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 83.4 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны эхний 10 сард 17.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.2 (21.9%) их наяд төгрөгөөр өслөө. Худалдааны салбарын борлуулалтын орлого аймгуудад 8.3-47.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, аймгаар, жил бүрийн эхний 10 сард, тэрбум төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Мөнгө, санхүү, үйлчилгээний статистикийн
хэлтсийн статистикч Л.Энхбаатар
Утас: (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212